



**ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын “Төрийн ордны тухай хууль”-ийн 2 дугаар бүлгийн 6.4, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2008 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн тушаалын 5.23, 5.24, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын дүрмийн 4.4.4 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Төрийн ордны хуралдааны танхимуудыг ашиглах журам”-ыг нэгдүгээр, Төрийн ордны хуралдааны танхимуудын ашиглалтын төлбөрийн үнэлгээг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын даргын 2011 оны 22, 23 дугаар тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Д.НЯМЖАВ

13 0075

ТЗҮЭГ-ын захирлын 2013 оны 34...
тушаалын нэгдүгээр хавсралт



ТӨРИЙН ОРДНЫ ХУРАЛДААНЫ ТАНХИМУУДЫГ АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн хүрээнд Төрийн ордны хуралдааны танхимуудыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын зохих зөвшөөрөлтэй хурал, зөвөлгөөн, уулзалт бусад арга хэмжээ явуулахад энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2.Хуралдааны танхимуудад Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын ивээл дор болон тэдгээрийн Тамгын газрын оролцоотой зохион байгуулж байгаа хурал, зөвөлгөөн, уулзалт, бусад арга хэмжээ зохион байгуулах асуудлыг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нар тус тус шийдвэрлэнэ.

1.3.Төрийн ордонд зохиогдох хурал зөвөлгөөн, уулзалт, бусад арга хэмжээний үйлчилгээний бэлтгэл хангах ажлыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар хариуцан зохион байгуулна.

1.4.Төрийн ордонд хурал, уулзалт, бусад арга хэмжээг зохион байгуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага нь үйлчлүүлэгч байгууллага байна.

Хоёр. Төрийн ордонд зохион байгуулагдах арга хэмжээний ангилал, дараалал

2.1.Монгол улсын Төрийн ордны тухай хуулиар тогтоогдсон хуралдаан;

2.2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурал, тэдгээрийн Тамгын газар, Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулж байгаа хурал, зөвөлгөөн, уулзалт, бусад арга хэмжээ;

2.3.Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүдээс зохион байгуулж байгаа хурал, зөвөлгөөн;

2.4.Төрийн өндөр хэмжээний айлчлал болон цаг үеийн шаардлагаар зайлшгүй зохион байгуулах төлөвлөгдөөгүй хуралдаан, арга хэмжээ зарлагдсан тохиолдолд өмнө төлөвлөгдсөн хурал, зөвөлгөөнийг хойшлуулах, цуцлах тухай арга хэмжээг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын Үйлчилгээний алба, тухайн зөвшөөрлийг олгосон Тамгын газрын даргатай ярилцсаны үндсэн дээр авч дараагийн хугацааг тохирно.

Гурав.Хуралдааны танхимыг ашиглахад хориглох зүйлс

Төрийн ордон түүний нутаг дэвсгэрт "Монгол Улсын Төрийн ордны тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дор дурдсан зүйлсийг хориглоно.

3.1.Төрийн ордны танхимуудад энэхүү журманд зааснаас бусад үйл ажиллагаа явуулах;

3.2.Хурлын танхимуудад зохиогдох арга хэмжээнд тухайн танхимын суудлын тооноос илүү тооны хүн оролцуулах;

3.3.Төрийн ордон дахь эд хөрөнгө, үзмэр, хүндэтгэлийн зүйлийг гэмтээх, танхимын эд хогшлын байршлыг дур мэдэн өөрчлөх;

3.4.Энэхүү журмын 2.1, 2.2-т зааснаас бусад төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагын захиалгаар аливаа арга хэмжээ зохион байгуулах;

3.5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгаатай холбоотой үйл ажиллагаа, урлагийн тоглолт, ойн арга хэмжээг зохион байгуулах.

Дөрөв.Журам зөрчсөн албан байгууллага, хувь хүнд хүлээлгэх хариуцлага

4.1.Монгол Улсын "Төрийн ордны тухай хууль", "Төрийн ордны хамгаалалт, үйлчилгээний журам", "Төрийн ордонд дагаж мөрдөх галын аюулгүйн журам" болон энэхүү журмыг зөрчигсдөд Монгол Улсын Төрийн ордны тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.2.Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар нь Монгол Улсын Төрийн ордны тухай хууль болон энэхүү журмыг зөрчсөн үйлдлийн талаар холбогдох Тамгын газар болон үйлчлүүлэгч байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

ТЗҮЭГ-ын захирлын 2013 оны 34...
тушаалын хоёрдугаар хавсралт



**ТӨРИЙН ОРДНЫ ХУРАЛДААНЫ ТАНХИМУУДЫН
АШИГЛАЛТЫН ТӨЛБӨРИЙН ҮНЭЛГЭЭ**

Д/д	Заалны нэр	Суудлын тоо	1 цагийн үнэлгээ /төгрөгөөр/		
			Төрийн байгууллага	Төрийн бус байгууллага	Олон улсын байгууллага
1	А заал	100	100,000	150,000	200,000
2	Б заал	100	100,000	150,000	200,000
3	В заал	50	50,000	70,000	90,000
4	Их танхим	800	300,000	350,000	400,000
5	“Нэр төрийн үнэлгээ”			30%	30%
6	Их танхимын II давхрын арын болон хажуугийн фойе	1 м2	500	1,000	1,500